



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



АШУУИС
МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМЫН АЖЛАЛЫН ГЭРЭЭ



ЕРӨНХИЙ МЭРГЭШИЛ СУДЛАЛ

Суралцагчийн дэвтэр



2022 он

Энэхүү дэвтэр нь Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2018 оны 10 дугаар сарын 02-ны тогтоолоор зөвшөөрснөөр Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/156 тоот тушаалаар батлагдсан.

Эрүүл Мэндийн Яам

Шуудангийн хаяг: Засгийн газрын 8 байр, Олимпын гудамж-2
Сүхбаатар дүүрэг 14210, Улаанбаатар хот Монгол улс
Утас: 976-51-263695, 976-51-263913
Цахим хаяг: www.mohs.mn
Цахим шуудан: info@moh.gov.mn

Эрүүл Мэндийн Хөгжлийн Төв

Шуудангийн хаяг: Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны гудамж-13Б, Улаанбаатар-210648
Факс: 976-11-320633
Утас: 976-11-325540
Цахим хаяг: www.hdc.gov.mn

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль

Шуудангийн хаяг: Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, С.Зоригийн гудамж, Ш/Х-46/111 Улаанбаатар хот 14210
Утас: 976-11-321194
Цахим хаяг: <http://mnums.edu.mn/>
Цахим шуудан: info@mnums.edu.mn

Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага /JICA/

Анхан ба хоёрдахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл

Хаяг: Эрүүл мэндийн хөгжлийн төв, 3 дугаар давхар, 306 тоот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны гудамж-13Б, Улаанбаатар-210648
Факс: 976-11-320633
Утас: 976-70110894
Цахим хаяг: www.facebook.com/JICApostgraduatetrainingProject/
Цахим шуудан: jica.pgthp@gmail.com

Энэхүү Суралцагчийн дэвтрийг Эрүүл мэндийн яамны зөвшөөрөлгүйгээр хувилах, олшруулах, хэвлэхийг хориглоно.



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



АШУУИС
АНГАГАА ДЭВЭЭН ТӨНӨН ТӨСӨВӨН ГЭЭГЧ



Эмч ба сувиллагчийн
үндэслэлийн дорваа сурталыг
сайжруулах төсөл

ЕРӨНХИЙ МЭРГЭШИЛ СУДЛАЛ

Суралцагчийн дэвтэр



2022 он

Боловсруулсан ажлын хэсэг:

Б.Баттогтох	АШУҮИС, Монгол-Японы эмнэлгийн стратеги төлөвлөлтийн менежер
М.Ундрэм	АШУҮИС, АУС, Өрхийн анагаахын тэнхимийн багш
Б.Мөнхцэцэг	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн мэргэжилтэн
Ц.Амаржаргал	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн мэргэжилтэн
Д.Дондогмаа	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн мэргэжилтэн

Зөвлөх:

Хиротака Ониши	Токиогийн их сургууль, Анагаах ухааны судалгааны тэнхим, Анагаахын боловсролын олон улсын судалгааны төвийн профессор
----------------	---


Хамтран ажилласан:

О.Түмэндэмбэрэл	“Монгол Улсын анхан ба хоёр дах шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах” төслийн ажилтан
А.Цэнгүнмаа	“Монгол Улсын анхан ба хоёр дах шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах” төслийн ажилтан

Хянан тохиолдуулсан:

Иноүэ Нобуаки	“Монгол Улсын анхан ба хоёр дах шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах” төслийн ахлах зөвлөх
Д.Баярмаа	ЭМЯ, Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн

СУРАЛЦАГЧ ЭМЧИЙН МЭДЭЭЛЭЛ



Овог

Нэр

Регистрийн дугаар

Сургалт эрхлэгч байгууллага

Элссэн огноо, тушаалын дугаар

Цахим шуудангийн хаяг

Утасны дугаар

Хариуцагч (ментор)- ийн мэдээлэл

Овог, нэр

Тасаг, нэгж, албан тушаал

Утасны дугаар

Цахим шуудангийн хаяг

ГАРЧИГ

I. УДИРТГАЛ

1.1. Суралцагчийн дэвтэр ашиглах тухай	5
1.2. “Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөр	8
1.3. Портфолио хөтлөх заавар	23
1.4. Нэр томъёоны тайлбар	25
1.5. Баримжаа олгох сургалт	27
А. Сургалтын өмнө	27
Б. Тойролтын өмнө	27

II. ЭМНЭЛЗҮЙН ДАДЛАГА, ТОЙРОЛТ ТУС БҮРЭЭП

2.1. Дотор судлал	29
2.2. Хүүхэд судлал	31
2.3. Эх барих, эмэгтэйчүүд судлал	33
2.4. Яаралтай тусламж судлал	35

III. ҮНЭЛГЭЭ

3.1. Зайлшгүй суралцах гардан үйлдлийн тэмдэглэл	37
3.2. Зайлшгүй суралцах шинж тэмдэгийн тэмдэглэл	39
3.3. Портфолиогийн тэмдэглэл	44

IV. СЕМИНАР, КОНФЕРЕНЦ, ЖУРНАЛ КЛУБ, ХУРЛЫН ИЛТГЭЛИЙН ТЭМДЭГЛЭЛ

4.1. Конференцийн тэмдэглэл	46
4.2. Журнал клубын тэмдэглэл	46
4.3. Эрдэм шинжилгээний хурлын тэмдэглэл	47
4.4. Эрдэм шинжилгээний өгүүллийн тэмдэглэл	47

V. ХАВСРАЛТ

5.1. Сургалт удирдах багш нарын мэдээлэл	48
5.2. Тойролт тус бүрийн үйл ажиллагааны хуваарь (загвар)	49
5.3. Ашиглах материалын жагсаалт	52
5.4. Mini-CEX үнэлгээний хуудас	53
5.5. DOPS үнэлгээний хуудас	55
5.6. Портфолиогийн үнэлгээний рубрик	57
5.7. 360 хэмийн үнэлгээний хуудас	59

I. УДИРТГАЛ

1.1. Суралцагчийн дэвтэр ашиглах тухай

I бүлэгт “Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөр, портфолио хөтлөх заавар, нэр томъёоны тайлбар, сургалтын өмнөх болон тойролтын өмнөх баримжаа олгох сургалтын тухай тусгагдсан.

“Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх болсон үндэслэл, эрхэм зорилго, алсын хараа, сургалтын төгсгөлд хүлээгдэж буй үр дүн, ерөнхий мэргэшлийн эмчийн цогц чадамж, сургалтыг удирдан зохион байгуулах арга зүй, хугацаа, байршил, сургалтын үндсэн агуулгын талаарх мэдээллий хөтөлбөрийн хэсэгт тусгасан. “Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлээр суралцагч эмч бүр хүний их эмч мэргэжлээр хаана, хэдэн онд төгссөнөөс үл хамааран үндсэн 7 чадамжийг сургалтын төгсгөлд эзэмшсэн байх зорилтыг өөртөө тавих нь зүйтэй. Үндсэн 7 чадамжийн хүрээн дэх 22 чадамжийг суралцагч эмч хэрхэн эзэмшиж байгааг портфолио үнэлгээ, 360 хэмийн болон mini-CEX –ээр үнэлнэ.

Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ, эргэн зөвлөгөө хэсэгт ажлын байранд суурилсан үнэлгээг хэрхэн хийх талаар “туршлага олж авсан үйлдлүүдийн жагсаалт ба түүний эргэцүүлэл” хүснэгтэд тусгасан болно. Энэхүү хүснэгтээс аль тойролтод ямар чадвар, хандлага, цогц чадамжийг үнэлгээний ямар хэлбэрээр үнэлүүлэх талаар олж мэднэ. Мөн үнэлгээний арга, хэлбэрийн тайлбарыг харж болно.

Ерөнхий мэргэшил судлал үндсэн мэргэшлийн сургалтын явцад суралцагч эмч портфолио хэрхэн хөтлөх талаар тайлбарыг “портфолио хөтлөх заавар” хэсэгт тусгасан.

Удиртгалын төгсгөлийн хэсэгт сургалтын өмнөх болон тойролтын өмнөх баримжаа олгох сургалтаар суралцагч эмч ямар мэдээллийг олж авч болох тухай тусгасан.

II бүлэгт үндсэн дөрвөн тойролтоор зайлшгүй танин мэдэж, суралцах шаардлагатай өвчний жагсаалт багтсан ба

тэдгээрийн оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлтэд суралцаж туршлага хуримтлуулсан тухайгаа тухай бүрт тэмдэглэж сургагч багшаар баталгаажуулах хэрэгтэй.

III бүлэгт сургалтын хугацаанд зайлшгүй суралцах гардан үйлдэл болон шинж тэмдэгт суралцсан тухайгаа тэмдэглэх хүснэгтүүд тусгагдсан.

Зайлшгүй суралцах 14 гардан үйлдлийг бие даан хийж чаддаг болтлоо DOPS үнэлгээ хийлгэх ба хэдэн удаа DOPS үнэлгээ хийлгэсэн, болон түүнийг баталгаажуулсан сургагч багшийн гарын үсгийг гардан үйлдлийн тэмдэглэл хэсэгт бичнэ.

Дараагийн хэсэгт зайлшгүй суралцах шинж тэмдэгт суралцсан тухайгаа тэмдэглэх хүснэгтийг хөтөлнө. Энэ хэсгийг бөглөхдөө зайлшгүй суралцах шинж тэмдгийн жагсаалтад тусгагдсан шинж тэмдгүүдээс тойролт бүрт хамгийн багадаа 5 шинж тэмдгийг сонгон суралцах ба суралцсан эсэхээ mini-Sex үнэлгээгээр тус бүр 3-аас дээш удаа үнэлүүлэн энэ хэсэгт тэмдэглэнэ.

Портфолиогийн тэмдэглэл нь суралцагч эмч сургалтын үндсэн зорилтуудыг хэрхэн хангаж буйг харуулах үнэлгээний гол хэсгийн нэг юм. Портфолиог хэрхэн хөтлөх талаар удиртгал бүлэгт тодорхой заасан болно. Суралцагч эмч сургалтын нэг жилийн хугацаанд портфолио хөтөлж, хариуцагч (ментор)-даа хамгийн багадаа 10 удаа удаа хянуулан, зөвлөгөө авна. III бүлгийн гуравт байгаа “портфолиогийн тэмдэглэл” хүснэгтэд портфолио бичиж эхэлсэн өдөр, ментороос зөвлөгөө авсан өдөр, ямар чадамжийг (7 чадамжийн алинд хамаарах) портфолиодоо тусгасан болон менторры өгсөн зөвлөмжийн агуулгыг бичиж, гарын үсгээр баталгаажуулаарай.

IV бүлэгт семинар, конференцд оролцсон байдлаа тэмдэглэх хүснэгтүүд байгаа. Сургалтын төгсгөлд суралцсан байх 7 чадамжийн нэг болох “тасралтгүй суралцагч” байх чадамжийн хувьд “(i) өөрийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхийн тулд хэрэгцээт сургалтад хамрагдах; (ii) өдөр тутам шинэчлэгдэж байгаа анагаах ухааны дэвшлээс

хоцрохгүйн тулд бие даан тасралтгүйгээр суралцах, олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг судлах, дүн шинжилгээ хийх; (iii) хамтран суралцагч эмч, бусад эмнэлгийн мэргэжилтэнд заах замаар өөрийн мэдлэг, ур чадвараа сайжруулах” чадварт суралцах нь зүйтэй. Иймд, нэг жилийн сургалтын хугацаанд мэргэжлийн хурал, семинар, конференц, журнал клубд идэвхтэй оролцон, “семинар, конференцийн тэмдэглэл” хэсэгт тэмдэглэж, удирдсан сургагч багшийн гарын үсгээр баталгаажуулна.

V бүлэгт хавсралт материалууд болох сургалт удирдах багш нарын мэдээлэл, сургалт эрхлэгч байгууллага, суралцагч эмчийн гэрээ, тойролт тус бүрийн үйл ажиллагааны хуваарь (загвар), ашиглах материалын жагсаалт, Mini-CEX үнэлгээний хуудас, DOPS үнэлгээний хуудас, портфолиогийн үнэлгээний рубрик, 360 хэмийн үнэлгээний хуудас тусгагдсан.

Сургалт эрхлэгч байгууллага бүрийн сургагч багш, сургалтын гэрээ, ажлын байран дахь болон танхимын сургалтын хуваарь, ашиглах материал (номзүй) ялгаатай байж болох тул хавсралтаар өгөгдсөн загварыг ашиглан, өөрсдийн эмнэлгийн онцлогийг харгалзан боловсруулж, эмнэлгийн даргаар баталгаажуулан та бүхний гарт хүргэнэ.

Сургалтын явцад ашиглагдах үнэлгээний хуудсуудыг мөн хавсралтаар өгсөн бөгөөд эдгээрийг өөрсдийн хэрэгцээгээр хэвлэн олшруулж ашиглах боломжтой.

1.2. “Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөр

Үндэслэл

Монгол Улсын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд цаашид ямар мэргэшлийн чиглэл сонгон суралцаж, хаана ажиллахаас үл хамааран эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг олон талт, цогц, уян хатан байдлаар үзүүлэх чадвартай хүний их эмч бэлтгэх шаардлагатай байна.

Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/184 дүгээр тушаалаар “Ерөнхий мэргэшил судлал”-ын үндсэн мэргэшлийн сургалтын чиглэл, индексийг шинээр баталсан ба Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалаар “Ерөнхий мэргэшил судлал”-ын үндсэн мэргэшлийн сургалтыг 1 жилийн хугацаатай, хүний их эмчийн бусад үндсэн мэргэшлийн сургалтын 1 жил нь “Ерөнхий мэргэшил судлал”-ын сургалт байхаар заасан тул энэхүү сургалтын хөтөлбөрийг боловсруулав.

Улсын Их Хурлаас 2016 онд шинээр баталсан “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль”-аар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэшлийн төв төдийгүй нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвд төгсөлтийн дараахь сургалт эрхлэхээр зохицуулсан тул “Ерөнхий мэргэшил судлал”-ын үндсэн мэргэшлийн сургалтыг нэн тэргүүнд аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвд явуулж, төгсөлтийн дараахь сургалт эрхлэх байгууллагын хүрээг тэлэх боломж бүрдсэн болно.

Эрхэм зорилго

Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд нийцэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх цогц чадвар бүхий эмч бэлтгэх.

Алсын хараа

“Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрөөр бэлтгэгдэх эмчийн дүр зураг:

Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон;

зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээ хийхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн; өвчтөнд энэрэх сэтгэлээр хандаж, эмчийн ёс зүйг чандлан баримталдаг, багаар ажиллан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үр дүнтэй үзүүлж чаддаг эмч байна.

Монгол улсын “Ерөнхий мэргэшлийн эмч”-ийн цөм чадамж

Алсын харааг биелүүлэхэд чиглэсэн дараахь цөм чадамжтай байна:

1. Ерөнхий мэргэшлийн эмч (*General Practitioner*)
2. Мэргэжлийн байх (*Professional*)
3. Суралцагч (*Learner*)
4. Харилцагч (*Communicator*)
5. Хамтрагч (*Collaborator*)
6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч (*Community Health Advocate*)
7. Зохион байгуулагч, манлайлагч (*Leader*)

Чадамж (*Competency*): Эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадвар, үнэ цэн, хандлага зэрэг олон бүрэлдэхүүн хэсгийг агуулсан, ажиглагдахуйц хүчин чадал-чадвар. Нэгэнт чадамж нь харагдахуйц тул түүнийг хэмжиж, эзэмшсэн эсэхийг үнэлж болно. Барилгын тоосгыг өрж угсрахтай адил чадамжийг хэрхэн эзэмших, хөгжихийг зааж чиглүүлж болно.

Сургалтын зорилт

Цөм чадамж бүхий эмч болохын тулд дараах дэд чадамжийг эзэмшиж, бие даан гүйцэтгэж чаддаг болно. Үүнд:

1.Ерөнхий мэргэжлийн эмч (*General practitioner*):

- Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчний шинж тэмдгийг (*signs and symptoms*) таньж ялган оношлох,

анхан шатны арга хэмжээг авах;

- Өвчтөнөөс асуумж авах, бодит үзлэг хийх, өвчтөний сэтгэл зүй, нийгмийн нөхцөл байдлыг үнэлж оношилгоо, эмчилгээ, хяналтын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;
- Орон нутгийн түвшинд хийгдэх оношилгоо, эмчилгээний гардан үйлдлийг бүрэн эзэмшиж, тусламж, үйлчилгээг аюулгүй үзүүлэх;
- Өвчтөний хувийн нууцыг хадгалах;
- Өвчтөний өвдөлт, сэтгэл зовнилд анхаарал хандуулах;
- Орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нөөц бололцоонд тулгуурлан, өвчтөнд үзүүлэх тусламж, үйлчилгээг шийдвэрлэх;
- Эрүүл мэндийн байгууллагын бүртгэл болон тайлангийн маягыг зохих журмын дагуу цаг хугацаанд нь хөтлөх.

2.Мэргэжлийн байх (*Professionalism*):

- Орон нутагт өөрийн мэргэшлээр хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзэлтэй байх;
- Өвчтөнийг хувь хүний хувьд хүндэтгэж, хамгийн оновчтой зөв шийдвэр гаргахын төлөө ажиллах;
- Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй хүндэтгэлтэй харилцах.

3.Суралцагч (*Learner*):

- Өөрийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхийн тулд хэрэгцээт сургалтад хамрагдах;
- Өдөр тутам шинэчлэгдэж байгаа анагаах ухааны дэвшлээс хоцрохгүйн тулд бие даан тасралтгүйгээр суралцах, олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг судлах, дүн шинжилгээ хийх;
- Хамтран суралцагч эмч, бусад эмнэлгийн мэргэжилтэнд заах замаар өөрийн мэдлэг, ур чадвараа сайжруулах.

4.Харилцагч (*Communicator*):

- Өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй зүй зохистой үг хэллэг ашиглан зөв боловсон харилцах;
- Өвчтөнд шаардлагатай мэдээлэл өгөхдөө ойлгоход хялбар үг хэллэг ашиглан тайлбарлах;
- Шаардлагатай тохиолдолд өвчтөний оношилгоо, эмчилгээний талаар бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй зөвлөлдөх.

5.Хамтрагч (Collaborator):

- Тухайн орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар мэргэшлийн эмч нартай мэдээлэл солилцож, хамтран ажиллах;
- Эмнэлгийн бусад тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг, мэдээллээ хуваалцаж хамтран ажиллах.

6.Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч (Community Health Advocate):

- Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байхын тулд урьдчилан сэргийлэх, тусламж, үйлчилгээ үзүүлэх, сургалт сурталчилгаа явуулах;
- Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

7.Зохион байгуулагч, манлайлагч (Leader):

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохицуулах, манлайлан ажиллах үүргээ ухамсарлах;
- Эмнэлэг, эрүүл мэндийн төв дэх тусламж, үйлчилгээ үзүүлэх багийг манлайлан ажиллах үүргээ ухамсарлах.

Сургалтын арга зүй

Сургалтын чиглэл, хугацаа, байршил

- Сургалтад дотрын анагаах судлал, хүүхэд судлал, эх барих, эмэгтэйчүүд судлал, яаралтай тусламж судлал гэсэн 4 чиглэлээр тойролт заавал хийж, эмнэлгийн

анхан шатны тусламж, үйлчилгээний сургалт болон сонгон суралцах чиглэлээр сургалтад хамрагдана.

- Сургалтын нийт хугацаа 1 жил байна. Тойролтын хугацааг сургалт эрхлэх байгууллага өөрийн онцлог, хүчин чадалд тохируулан зохицуулна.
- Сургалтын нийт хугацаанд эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээний сургалт (өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд) 1 сараас доошгүй хугацаанд явагдана.
- Сонгон суралцах чиглэлийг сургалт эрхлэх байгууллагаас гаргасан чиглэлээс сонгох ба сургалтын хугацаа нь 1 сар хүртэл байна.
- Суралцагч эмчийн өдөр тутмын болон 7 хоногийн үйл ажиллагааны тодорхой хуваарийг сургалт эрхлэх байгууллагаас боловсруулна.
- Эмнэл зүйн мэргэшүүлэх сургалт эрхлэх байгууллагад тавигдах шаардлага хангаж, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөс “Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрөл авсан эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллага энэхүү сургалтыг явуулна.
- Нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв нь энэхүү сургалтын үндсэн байгууллага байна. Хэрэв сургалт явуулах хангалттай орчин бүрдээгүй тохиолдолд бусад эрүүл мэндийн байгууллагыг оролцуулан сургалт эрхлэх байгууллагын сүлжээ үүсгэн хамтарч ажиллана.
- “Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрөл авсан эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллага (сургалт эрхлэх байгууллагын сүлжээнд нэгдсэн бусад байгууллага)-ын амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг, яаралтай тусламжийн тасаг, мэс заслын тасаг, хурлын танхим, сургалтын анги танхимд сургалт явагдана.

Танхимын болон ажлын байран дахь сургалтын хуваарь Ажлын байрны сургалт (*On-the-Job Training*)-ын загвар

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч/Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Амбулаторийн үзлэг хийх	1	3 цаг 7 хоногт 2 удаа	Амбулатори	Өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш
Хяналтын тойрон үзлэг хийх	3 - 5	1 цаг Өдөр бүр	Тасаг	Өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш
Сургалтын тойрон үзлэг хийх	20 хүртэл	1 цаг 7 хоногт 1 удаа	Сургалтын өрөө, танхим	Слайд	Эмнэл зүйн сургагч багш
Мэс засалд оролцох	1	Тохиолдол байгаа үед	Мэс заслын өрөө	Өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш
Жирэмсэн, төрсний дараах хяналт хийх	1	Хяналтад байгаа жирэмсэн эх, төрсөн эх	Амбулатори, гэрээр	Жирэмсэн эх, төрсөн эх	Эмнэл зүйн сургагч багш
Төрөлт удирдахад оролцох	1	Тохиолдол байгаа үед	Төрөх өрөө	Өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш
Гардан үйлдэл хийх	1 - 2	Тохиолдол байгаа үед	Яаралтай тусламжийн өрөө	Өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч

Хяналтын тойрон үзлэг:

Хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөний биеийн байдлыг суралцагч эмч нь эмнэл зүйн сургагч багшид (бусад эмч) танилцуулах зорилготой үзлэг.

Үүний тулд суралцагч эмч нь урьдчилан бие даан өвчний түүх, сувилагчийн тэмдэглэлийг үзэж танилцан, өвчтөнтэй уулзаж асуумж цуглуулж (ганцаарчилсан үзлэг), эмнэл зүйн сургагч багшид (бусад эмч) танилцуулахад бэлдэнэ. Танилцуулга хийхдээ хувь хүний мэдээллийг анхаарна. Танилцуулгыг сургалтын өрөө, танхим эсвэл өвчтөний өрөөнөөс гадна хийх ба өвчтөний орны дэргэдэх тойрон үзлэгийг эмнэл зүйн

сургагч багштай (бусад эмч) хамт хийнэ. Хяналтын тойрон үзлэгээр өвчтөнөөс асуумж авах, үзлэг хийх аргад суралцана.

Сургалтын тойрон үзлэг:

Сургалтад тохиромжтой 1 - 2 өвчтөнг сонгож, өвчтөний биеийн байдлыг суралцагч эмч нь танилцуулах ба бусад оролцогчид (хамтран суралцагч эмч, эмнэл зүйн сургагч багш, бусад эмч) асуулт тавьж, хэлэлцүүлэг өрнүүлнэ.

1 тохиолдолд 30-60 минут зарцуулна. Үүний дараа өвчтөний орны дэргэд үзлэг хийнэ. Хэлэлцүүлгийн явцад эмнэл зүйн таамаглал дэвшүүлэх, онош тавих зэрэгт суралцана.

Танхимын сургалт (*Off-the Job Training*)-ын загвар

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэг-дэхүүн	Удирдагч, хамтрагч
Бие даалт	1	Тохиромжтой, чөлөөт цаг	Гэртээ, номын сан	Ном, интернет	Өөрөө, хамтран суралцагч эмч
Лекц	20 хүртэл	7 хоногт 2-3 удаа 1 цаг	Сургалтын анги, танхим	Слайд	Эмнэл зүйн сургагч багш, хамтран суралцагч эмч
Журнал клуб	20 хүртэл	7 хоногт 1 удаа 1 цаг	Сургалтын анги, танхим	Слайд, эрдэм шинжилгээний өгүүлэл	Эмнэл зүйн сургагч багш, хамтран суралцагч эмч
Симуляци (дуураймал орчин)	5 хүртэл	7 хоногт 1 удаа 1 цаг	Яаралтай тусламжийн өрөө	Хамтран суралцагч эмч, манекин	Эмнэл зүйн сургагч багш

Сургалтын агуулга

Сургалтын төгсгөлд орон нутагт ганцаараа бие даан тусламж, үйлчилгээ үзүүлж чадах түвшинд хүрэхийн тулд эмнэл зүйн сургагч багшийн хяналт дор амбулаториор ирэх өвчтөн,

хэвтэн эмчлүүлэх өвчтөний оношилгоо, эмчилгээг хариуцан хийх явцдаа дараах шинж тэмдэг, өвчин, гардан үйлдлийг гүйцэтгэж, туршлага хуримтлуулна.

Зайлшгүй танин мэдэж, суралцах шаардлагатай шинж тэмдэг (*signs and symptoms*) (аль ч тойролтод тохиолдох):

Өвчний түүх, бодит үзлэгт үндэслэн эрэмбэлэн ангилж, ялган оношлогоо хийн, анхан шатны эмчилгээг эхлүүлж чаддаг болох:

1. Халууралт (*Fever*)
2. Шарлалт (*Jaundice*)
3. Толгой өвдөлт (*Headache*)
4. Ухаан алдалт, баларталт (*Altered level of consciousness*)
5. Таталт (*Seizure*)
6. Амьсгаадалт (*Dyspnea*)
7. Ханиалгалт, цэр гаралт (*Coughing, Excretion sputum*)
8. Цээжээр өвдөлт (*Chest pain*)
9. Зүрх зогсолт (*Cardiac arrest*)
10. Цустай бөөлжилт (*Hematemesis*)
11. Цустай өтгөн, цустай гүйлгэлт (*Melena*)
12. Дотор муухайралт, бөөлжилт (*Nausea, Vomiting*)
13. Хэвлийн өвдөлт (*Stomachache*)
14. Суулгалт (*Diarrhea*)
15. Шингэн алдалт (*Dehydration*)
16. Нуруугаар өвдөлт (*Back pain*)
17. Мөчдийн саажилт (*Paralysis*)
18. Сэтгэл гутрал (*Depression*)
19. Хаван (*Edema*)
20. Үений өвдөлт (*Arthralgia*)
21. Лимфийн булчирхайн томролт (*Lymph node swelling*)
22. Цус алдалт (*Hemorrhagic tendency*)

Зайлшгүй суралцах гардан үйлдлийн жагсаалт

1. Судасны хүрц (ясанд шингэн сэлбэх хүрц) (*Intravenous*)

- access (intraosseous access)*
2. Амьсгалын зам чөлөөлөх энгийн арга (*Manual airway management*)
 3. Амилуулах тусламж, зүрх уушгины сэхээн амьдруулалт (насанд хүрэгч) (*Cardiopulmonary resuscitation (adult)*)
 4. Зүрх уушгины сэхээн амьдруулалт (нярай, хүүхэд) (*Cardiopulmonary resuscitation (infant, child)*)
 5. Цус авах (*Blood drawing*)
 6. Тариа хийх (судас тариа, булчин тариа, арьсан дор) (ялангуяа нярай, бага насны хүүхдэд) (*Injection (intravenous, intramuscular, subcutaneous)*)
 7. Оёдол тавих (цус тогтоох, шарх цэгцлэх) (*Suturing (Hemostasis, Wound irrigation)*)
 8. Ходоодонд хаймсуур тавих (хүнд хэлбэрийн шингэн алдалтын эмчилгээ: Хүүхдийн өвчний цогц менежмент) (*Nasogastric tube (treatment for severe dehydration)*)
 9. Давсанд гуурс байрлуулах (*Foley catheter insertion*)
 10. Зүрхний цахилгаан бичлэг хийх (*Electrocardiogram*)
 11. Цусан дах сахарын хэмжээг тодорхойлох (*Checking blood sugar*)
 12. Хэт авиа оношилгоо (яаралтай тусламж): анхан шатны оношилгоо (*Ultrasound (emergency room) basic examination*)
 13. Хэт авиан оношилгоо (эх барих, эмэгтэйчүүд): жирэмсэнтэй холбоотой анхан шатны үнэлгээ, оношилгоо (*Ultrasound (Obstetrics & Gynecology) Basic evaluation for pregnancy*)
 14. Эх барих, эмэгтэйчүүдийн гардан үйлдэл: гадуур үзлэг, үтрээний үзлэг, эсийн шинжилгээ (*Obstetric and gynecologic examination technique: External examination and Vaginal examination (manual and with speculum)*)

Үнэлгээ, эргэн зөвлөгөө

Суралцагч эмч ба хариуцагч

Сургалтын 1 жилийн хугацаанд суралцагч эмч бүрт хэрхэн ахин дэвшиж байгаа, хэрхэн сайжруулах тухай эргэн зөвлөгөө

өгөх, суралцагч эмчийн хувийн төлөвлөгөөний (*career plan*) талаар зөвлөлдөх, тэднийг хариуцан ажиллах ментор (*mentor*) цаашид “хариуцагч эмч, багш” гэх)-ийг оноож хуваарилна. Суралцагч эмч нь сургалт эхлэх үед хариуцагчтай уулзах ба цаашид 2-3 сар тутамд 1 удаа уулзаж ярилцан, үнэлгээтэй танилцаж, эргэн зөвлөгөө авна.

Суралцагч эмч ба эмнэл зүйн сургагч багш

- Суралцагч эмчийн тойролт бүрт сургалт удирдах эмнэл зүйн сургагч багш оноож хуваарилна:
- Суралцагч эмч нь тухайн тойролт эхлэхээс өмнө эмнэл зүйн сургагч багштай уулзаж, тойролтын хугацаанд тавьсан зорилтоо ярилцана.
- Суралцагч эмч нь тойролтын явцад тавьсан зорилтод хүрэхийн тулд дутагдаж байгаа зүйл, түүнийг нөхөхөд хэрэгцээтэй байгаа зүйлийн тухай эмнэл зүйн сургагч багштай ярилцана.
- Суралцагч эмч нь тойролт дуусахад эмнэл зүйн сургагч багштай ярилцлага хийж, сургалттай холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө авна.

Ажлын байранд-суурилсан үнэлгээ (*Workplace-based Assessment*)

Эзэмшсэн туршлага, чадамж, хандлага ба түүний эргэцүүлэл:

Сургалтын зорилт		Дотор	Хүүхэд	Яаралтай тусламж	Эх барих эмэгтэйчүүд	Бусад
Туршлага	Шинж тэмдэг ба хам шинж	(L) Шинж тэмдэг ба хам шинжийн жагсаалт				
	Өвчний менежмент	(F) Тохиолдлын дүгнэлт (L) Сургагч багштай хамт эргэцүүлэх (Тойролт бүрт хамаарна)				
	Гардан үйлдэл	(F) DOPS/ mini-CEX	(F) DOPS/ mini-CEX	(F) DOPS/ mini-CEX	(F) DOPS/ mini-CEX (L) Төрөлтийн тэмдэглэл	(F) DOPS
		(F) DOPS-Гардан үйлдлийн ур чадварыг шууд ажиглан үнэлэх (L) Гардан үйлдлийн жагсаалт				

Чадамж	<p>Суралцагч бүр чадамжийг эзэмшиж туршлага хуримтлуулахын тулд бүх боломжийг ашиглахыг эрмэлзэнэ.</p> <p>Хариуцагч нь (mentor) эдгээр 7 чадамжид тохирох эмнэлзүйн тохиолдлыг олж, үйл ажиллагааг төлөвлөхөд туслах ба суралцагчийн ахицыг жилд 4 удаа үнэлж, портфолиод тусгаж хөтлөхөд зөвлөнө.</p>	(P) Ерөнхий мэргэшлийн – өдөр бүрийн тохиолдлыг эргэцүүлэн тунгаах
		(P) Мэргэжлийн байх – Мэргэжлийн эсвэл ёс зүйн асуудлыг хөндсөн тохиолдлыг эргэцүүлэн тунгаах
		(P) Суралцагч – Нотолгоонд суурилсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үйл ажиллагаагаа эргэцүүлэн тунгаах
		(P) Харилцагч – Харилцахад хүндрэлтэй тохиолдол ба түүнийг эргэцүүлэн тунгаах
		(P) Хамтрагч – Зохион байгуулах чадварт гарсан ахиц дэвшлээ эргэцүүлэн тунгаах
		(P) Хүн амын ЭМ-ийн зөвлөгч – орон нутагт зохион байгуулсан эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаагаа эргэцүүлэн тунгаах
		(P) Зохион байгуулагч, манлайлагч – бусдын тусламжийг авсан тохиолдлоо эргэцүүлэн тунгаах
Хандлага	<p>360 хэм үнэлгээг сургалтын албанаас зохион байгуулах ба сургалтын явцад 2 удаа хийнэ.</p> <p>Үнэлгээг (i) сургагч багш, (ii) сувилагч, (iii) эмнэлгийн бусад мэргэжилтэн, (iv) тасгийн эмч, (v) өвчтөн зэрэг 5-аас доошгүй хүн тус тусдаа хийнэ.</p> <p>Үнэлгээний хуудсыг сургалтын алба нэгтгэж хадгална.</p>	
	360 хэм үнэлгээнд менторууд мөн оролцох ба үнэлгээний хуудсыг сургалтын алба тусад нь хадгална.	

(F)- *Form* Үнэлгээнд зориулсан тусгай хуудас бөгөөд сургагч багшид хадгалагдана.

(L)- *Logbook* Сургагч багш болон менторт зориулсан байнгын шалгах, гарын үсэг зурах, тэмдэглэхэд зориулсан дэвтэр

(P)- *Portfolio* Суралцагч эмчийн суралцсан зүйлс болон өөрийн мэдлэг, ур чадварт хийсэн дүгнэлтийг хураангуйлан тэмдэглэж хадгалсан хавтас.

DOPS (*Direct observation of procedural skills*)- Гардан үйлдлийн ур чадварыг шууд ажиглан үнэлэх,

CEX (*Clinical evaluation exercise*)-Эмнэл зүйн үнэлгээний дасгал

360 хэмийн үнэлгээ (360-Degree Assessment):

Суралцагч эмчийн мэргэжлийн байх (professionalism) болон зохион байгуулагч, манлайлагч (leader) байх зэргийг үнэлэхэд хэрэглэнэ. 1 жилийн сургалтын дунд үе болон төгсөх үед хийнэ. Тойролтыг удирдсан эмнэл зүйн сургагч багш, сувилахуйн мэргэжилтэн, тухайн тасаг, нэгжийн хамтран ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, өвчтөн зэрэг нийт 5 хүн тус тусдаа үнэлнэ. Үнэлгээ хийх хүнийг сургалтын албанаас сонгоно. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өгнө. (360 хэмийн үнэлгээний хуудсыг хавсралтаас харна уу)

Mini-CEX/Эмнэл зүйн дасгал үнэлгээ (Mini-Clinical Evaluation Exercise) :

Зайлшгүй таньж мэдэх 22 шинж тэмдгээс тойролт бүрт 5-аас доошгүй шинж тэмдгийг тус бүр 3 болон түүнээс дээш удаа Mini-Cex үнэлгээгээр үнэлүүлсэн байна. Өөр тойролтонд ижил шинж тэмдгээр үнэлгээ хийсэн ч болно. (Жишээ нь: Дотрын тойролтод халууралтыг оролцуулан 5 шинж тэмдгээр үнэлгээ хийсэн бол хүүхдийн тойролтод ч мөн халууралтыг оролцуулж үнэлгээ хийлгэж болно).

Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах зөвлөгөө заавал өгнө. (Mini-CEX үнэлгээний хуудсыг хавсралтаас харна уу)

Гардан үйлдлийн ур чадварыг шууд ажиглан үнэлэх / DOPS

(Direct Observation of Procedural Skills):

Зайлшгүй сурах 14 гардан үйлдлээс 11-ээс доошгүйг хийж чаддаг болсныг эмнэл зүйн сургагч багш нотолж, баталгаа

өгөх хүртэл давтан үнэлгээ хийнэ.

Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах зөвлөгөө заавал өгнө. (DOPS үнэлгээний хуудсыг хавсралтаас харна уу)

Портфолио үнэлгээ (Portfolio Assessment):

Суралцагч эмч нь сургалтын хугацаанд суралцсан лекц, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний сургалтын үеэр эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа хийсэн материал зэрэг сургалттай холбоотой бусад бичиг баримтыг үр дүн болгож хадгална. (Рубрик, портфолиогийн талаарх дэлгэрэнгүй зааврыг хавралтаас харна уу)

Үнэлгээний дүнг хянах

- 360-хэмийн үнэлгээний дүнг сургалтын алба хяналт тавьж, хадгална. Үнэлгээний дүнг суралцагч эмч, хариуцагчид танилцуулах ба бусадтай хуваалцахгүй байхыг анхааруулна.
- Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг суралцагч эмч өөрөө хадгална.
- Портфолиод үнэлгээ, эмнэл зүйн сургагч багштай зөвлөлдсөн асуудал, өгсөн зөвлөгөөг бичиж тэмдэглэн хадгална.
- Суралцагч эмч нь тойролт бүрийн төгсгөлд Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг сургалтын албанд хүлээлгэн өгнө.
- Сургалтын алба үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд танилцуулах ба сургалтын төгсгөлд хариуцагчаас суралцагч эмчид зөвлөгөө өгнө.

Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх

Тойролт бүрт хийгдсэн Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг нэгтгэсний үндсэн дээр суралцагч эмчийг тухайн тойролтыг

төгсгөх эсэх шийдвэрийг сургалтын хяналтын зөвлөл гаргана. Сургалтын хяналтын зөвлөл нь тойролт бүрт хийгдсэн Mini-CEX болон DOPS үнэлгээний дүн, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн сургалтын ирц, зайлшгүй таньж мэдэж суралцах шинж тэмдэг, өвчний тохиолдол, гардан үйлдлийн тоог харгалзан сургалтын төгсөлтийн эцсийн шийдвэрийг гаргана. Шийдвэр гаргах шалгуур нь:

- Зайлшгүй сургалтад оролцсон байх өдрийн тоо буюу сургалтын ирц: Хөдөлмөрийн тухай хуульд заасан цалинтай амралтын өдрийн тоо, хүндэтгэх шалтгаантай авах амралтын өдрийн тоог оруулаад сургалтын хугацаанд авах амралтын өдрийн тоог сургалтын тойролт тус бүрийн нийт өдрийн 20%-аас хэтрүүлэхгүй байна. Сургалтын ирц хангалтгүй бол тухайн тасарсан сургалтын өдөр, агуулгыг нөхүүлнэ.
- Зайлшгүй таньж мэдэх шаардлагатай 22 шинж тэмдгээс 1 жилийн турш 18-аас доошгүйг оношилж, эмчлэн туршлага хуримтлуулсан байна.
- Зайлшгүй туршлага хуримтлуулсан байх шаардлагатай өвчний тохиолдлын тоо нь:
 - Дотрын анагаах судлал, хүүхэд судлалын тойролт бүрт заагдсан өвчний бүх тохиолдлыг тус бүр 5-аас доошгүй удаа үзэж, туршлага хуримтлуулсан байна.
 - Эх барих, эмэгтэйчүүд судлалын тойролтоор 30-аас доошгүй удаа төрөлт удирдахад оролцсон байх шаардлагатай. Жирэмсний хяналт, төрсний дараах үзлэгийг тус бүр 5-аас доошгүй хийж, туршлага хуримтлуулсан байна.
 - Яаралтай тусламж судлалын тойролтоор 1 жилийн турш зайлшгүй суралцах 10 төрлийн тохиолдлоос 8-ыг оношилж, анхан шатны тусламж үзүүлсэн байна.
- Зайлшгүй суралцах 14 гардан үйлдлээс 1 жилийн турш 11-ээс доошгүйг хийж гүйцэтгэн, туршлага хуримтлуулсан байна.

- Тойролт бүрийн төгсгөлд эсвэл 1 жилийн сургалтын эцэст суралцагчийг төгсгөх боломжгүй гэсэн шийдвэр гарсан тохиолдолд шалтгаан, цаашид сургалтыг хэрхэн төгсгөх талаарх шийдвэр, зөвлөмжийг сургалтын алба болон хариуцагчаас тухайн суралцагч эмчид тайлбарлаж өгнө.

Төгсөлтийн шалгалт

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулах “Ерөнхий мэргэшил судлал”-ын сургалтын төгсөлтийн шалгалт өгнө. Шалгалтад тэнцсэн тохиолдолд “Ерөнхий мэргэшлийн эмч”-ийн үнэмлэх олгоно.

1.3. Портфолио хөтлөх заавар

Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн мөн чанар нь сургалтын төгсгөлд суралцагчийн хүрэх үр дүнд онцгойлон анхаардаг. Сургалтын явц, зорьсон зорилтууддаа хэрхэн хүрч байгааг үнэлэх нэг хэлбэр нь портфолио үнэлгээ юм. Портфолио нь өдөр тутмын үйл ажиллагаа, суралцсан зүйлсээ нэгтгэх, дүгнэх, задлан шинжлэх, зөвлөгөө авч дутагдалтай байгаа чадамжаа сайжруулах хувь хүний хөгжлийн хэрэгсэл юм.

Портфолиогийн бүтэц

- Сэдэв
- Тухайн тохиолдлыг сонгосон шалтгаан
- Тохиолдлын танилцуулга
 - Үндсэн мэдээлэл
 - Онош, шийдвэрийн үндэслэл
 - Гаргасан шийдвэр (эмчилгээ, оношилгоо, менежментийн төлөвлөгөө)
 - Хүрсэн үр дүн (өвчтөний сайжрал, эдгэрэл, ...)
 - Сургагч багш, бусад мэргэжилтний санал, зөвлөмж
- Эргэцүүлэл, дүгнэлт
 - Тохиолдлыг шийдвэрлэхдээ сайн хийсэн зүйлс;
 - Цаашид анхаарах зүйлс. Ижил тохиолдолтой дахин таарвал юун дээр анхаарах вэ? гэдгийг бичих;
 - Тухайн тохиолдолд сэтгэл хөдлөлөө хэрхэн удирдсан талаараа эргэцүүлэх;
 - Суралцагч эмч тухайн шийдвэрлэсэн тохиолдолдоо зөвхөн өөрийн зүгээс биш, бусдын өгсөн санал зөвлөмж, уншсан материал, эх сурвалжид үндэслэн эргэцүүлэл дүгнэлт хийхэд анхаарах;
 - Сайжруулах зүйлсээ үндэслэлтэй бичих
- Ном зүй

Өдөр тутмын тэмдэглэл

- Өдөр тутмын тэмдэглэл дараах бүтэцтэй байж болно.
- Өдөр тутмын үзлэгийн тэмдэглэл;
- Эмнэлзүйн асуудал шийдвэрлэсэн тэмдэглэл;
- Журнал клуб, семинар, конференц, хурал зөвлөгөөн, лекц, уншсан материал гэх мэт сурч мэдсэн зүйлсийн тэмдэглэл;
- Өвчтөнтэй хийсэн ярилцлагыг дуу хураагуураар бичих (өвчтнөөс бичгээр зөвшөөрөл авсан байх);
- Суралцагч эмчийн өөртөө хийсэн дүгнэлт, эргэцүүлэл.

Портфолио бичихэд анхаарах зүйлс

Өдөр тутмын тэмдэглэлдээ үндэслэн үнэлгээ, эргэн зөвлөгөө авах чадамжийн хүрээнд портфолиогийн тэмдэглэл хөтлөхдөө дараах зүйлсийг анхаарна:

- Хөтөлбөрийн зорилтод тусгагдсан 7 чадамжаас аль нэгийг сонгох;
- Тухайн чадамжид хамгийн сайн тохирох тохиолдлыг өдөр тутмын тэмдэглэлээсээ сонгох;
- Портфолио А4-ийн 2 нүүрэнд (мөр хоорондын зай 1.15, үсгийн өндөр 12, Arial фонд) багтаан дээрх бүтцээр бичих;
- Портфолио бичихдээ хавсралтад тусгагдсан үнэлгээний шалгуур (рубрик)-ыг харгалзах;
- Найруулга зүй, үг зүй, зөв бичгийн дүрмийн мэдлэг чухалчлах;
- Сургалтын хугацаанд 7 чадамж бүрийг үнэлүүлсэн байх;

1.4. Нэр томъёоны тайлбар

